

ХҮН АМЫН ГЭРЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ БА АНХНЫ ГЭРЛЭЛТИЙН ДУНДАЖ НАС

Т.Уянга,

Эдийн засагч-хүн ам зүйч,
ҮСГ-ын Хүн Амын Тооллого
Судалгааны Төвийн мэргэжилтэн

Гэрлэлтийн байдал нь хүн ам зүйн нэг гол үзүүлэлт төдийгүй нийгмийн харилцааны нэн чухал асуудал юм. Гэрлэлтийн байдлын түүхэн өөрчлөлтийг судлах нь гэрлэлтийн ойрын болон ирээдүйн чиг хандлагыг илэрхийлэх боломж олгохоос гадна гэр бүлийн гишүүдийн харилцааг бэхжүүлэх, тэдний гэр бүлдээ болон нийгэмдээ гүйцэтгэх үүргийг боловсронгуй болгон сайжруулахад чиглэсэн төрийн бодлого боловсруулах, судлахад шаардлагатай нарийвчилсан мэдээллээр хэрэглэгчдийг хангах чухал ач холбогдолтой билээ.

Энэхүү ажилд, Монгол улсын удаа дараагийн хүн амын тооллогоорх гэрлэлтийн холбогдох мэдээллүүдэд үндэслэн хүн амын гэрлэлтийн байдал, анхны гэрлэлтийн дундаж нас, тэдгээрийн динамикт судалгаа хийж, өөрчлөлтөд нь нөлөөлж буй зарим нэгэн хүчин зүйлүүдийг хүн ам зүйн болон нийгэм, эдийн засгийн ялгавартай байдлаар нь дэлгэрэнгүйгээр тодорхойлж гаргасан юм. Түүнчлэн уншигч та энэ ажлаас хүн амын гэрлэлтийн байдалд гарч буй зарим сөрөг өөрчлөлтүүд, тэдгээрийг шийдвэрлэх талаарх тодорхой санал, зөвлөмжүүдийг унших боломжтой.

Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод "Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж, түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын анхааралд байлгана" гэж заасан нь өнөөгийн төр, засгаас гэр бүлийн талаар баримтлах бодлогын үндэс болж байна. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор гэрлэлтийн байдлын талаар цуглуулсан мэдээлэл нь өмнөх тооллогуудын дүнтэй харьцуулах боломжтой учраас гэрлэлтийн байдлын өөрчлөлтийн динамикийг уг судалгаанд тулгуурлав. Мөн хүн амын гэрлэлтийн байдлыг нас, хүйс, байршил, анхны гэрлэлтийн дундаж нас, түүний өөрчлөлт, түүнд нөлөөлж буй зарим нэгэн хүчин зүйлүүдийг тодорхойлоход чиглүүлсэн нь судалгааны үндсэн зорилт байлаа.

Гэрлэлтийн байдал нь хүн ам зүйн нэг гол үзүүлэлт төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад чухал ач холбогдолтой учир манай улсын удаа дараагийн хүн амын тооллогоор гэрлэлтийн талаар холбогдох мэдээллийг байнга цуглуулж ирсэн ба энэ нь хүн амын гэрлэлтийн байдлын түүхэн өөрчлөлтийг судлах боломжийг олгож байгаа юм. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогод гэрлэлтийн асуудлыг НҮБ-ын аргачлалтай нийцүүлэн өмнөх тооллогуудынхаас арай өргөжүүлэн оруулснаар зах зээлийн нөхцөлд гэр бүл, түүний гишүүдийн харилцааг төгөлдөржүүлэн сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд тус дэм болохуйц бодлогын чанартай зарим санал дүгнэлт дэвшүүлэх боломжтой болсон билээ. Түүнчлэн хүн ам, орон сууцны 2000 оны тооллогод олон улсын нийтлэг жишиг аргачлалтай нийцүүлэн хүн амын гэрлэлтийн байдлыг арван тав, түүнээс дээш насны хүн амаас асуусан

нь судалгааны хамрах хүрээг өргөжүүлж, гэрлэлтийн ойрын болон ирээдүйн чиг хандлагыг илэрхийлэх боломж олгож байгаагаас гадна гэр бүлийн гишүүдийн харилцааг бэхжүүлэх, тэдний гэр бүлдээ болон нийгэмдээ гүйцэтгэх үүргийг боловсронгуй болгон сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, судлахад шаардлагатай нарийвчилсан мэдээллээр хэрэглэгчдийг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа болно.

Гэрлэлтийн байдал нь хүн амын төрөлтийн чиг хандлагыг илэрхийлэх үндсэн нөхцлүүдийн нэг билээ. Энд, гэрлэлтээс гадна ялангуяа хүн ам зүйн нэг гол үзүүлэлт болох анхны гэрлэлтийн дундаж насыг сүүлийн хэд хэдэн тооллогын онуудаар, мөн яс үндэс, байршил, боловсрол, эдийн засгийн идэвх, ажил мэргэжлээр тооцож гаргасан болно.

Хүн амын гэрлэлтийн ерөнхий төлөв байдал

Хүн амын гэрлэлтийн байдал нь хүн ам зүйн шинжлэх ухаанд гэрлэлт, салалт, бэлбэсрэлт, тусгаарлалт, дахин гэрлэлт зэрэг ухагдахуунуудын цогцоор илэрхийлэгддэг. Эдгээр үзүүлэлтүүд гэрлэлт гэсэн ойлголтыг тал бүрээс нь тодорхойлон гаргадаг. Монгол Улсын 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан "Гэр бүлийн тухай" хуулинд: "Гэр бүл гэдэг нь гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ" гэж, харин "гэрлэлт гэдэг нь харилцан эрх тэгш эрх, үүргийн үндсэн дээр эрэгтэй, эмэгтэй хүмүүс тодорхой ёслол, үйл ажиллагааны дүнд сайн дурын бат холбоо тогтоож хуулиар батлуулах явдал юм" гэж заасан байдаг.

Гэрлэлт гэдэг нь хүмүүс гэр бүлээ албан ёсоор бүртгүүлэх явдлаар илэрнэ. Манай улсын хувьд гэрлэлтийн түвшин чиг хандлага ямар байсныг авч үзье.

Гэрлэлтийн талаарх тодорхой тойм тоо байхгүй ч ХХ зууны эхэн үеийн Монголын нийгэм, улс төрийн онцгой үйл явдлууд нь тухайн үеийн хүн амын гэрлэлтийн түвшинг илэрхийлж чадахуйц байлаа. 1935-1944 онд Монголын хүн амын тоо 738.2-759.1 мянга байсан ба жил бүр дунджаар 80000 орчим эрчүүдийг цэргийн албанд татаж байсан бол насанд хүрсэн нийт эрчүүдийн 40 орчим хувь нь сүм хийдэд эхнэр авалгүй шавилан сууж байлаа. Түүнчлэн тухайн үед гэрлэх насанд хүрсэн нийт эмэгтэй хүн амын 30-40 орчим хувь нь гэр бүлгүй байсан байна. Энэхүү байдал нь хүн амын төрөлт болон өсөлтөнд үлэмж сөрөг нөлөө үзүүлж байсан билээ.

1960-аад оноос эхлэн төрөөс хүн ам, нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах талаар тууштай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд гэр бүлгүй хүн амын тоо багасаж, хүйсийн харьцаа тодорхой хэмжээгээр тогтворжих хандлага ажиглагдаж эхэлсэн юм (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, 1979, 1989, 2000

Гэрлэлтийн байдал	1979		1989		2000	
	мян.хүн	ЭЗЛЭХ ХУВЬ	мян.хүн	ЭЗЛЭХ ХУВЬ	мян.хүн	ЭЗЛЭХ ХУВЬ
Бүгд	778.7	100.0	1052.0	100.0	1524.4	100.0
Огт гэрлээгүй	179.8	23.1	265.5	25.3	505.1	33.1
Батлуулсан/батлуулаагүй						
гэр бүлтэй	509.1	65.4	692.5	65.8	880.4	57.8
Цуцалсан/тусгаарласан	14.4	1.8	17.1	1.6	41.5	2.7
Бэлбэсэн	75.4	9.7	76.9	7.3	97.4	6.4

1979 оны тооллогоор нийт хүн амын 65.4 хувь нь гэр бүлтэй байсан бол 1989 онд энэ тоо 65.8 хувь, 2000 онд 57.8 хувь болжээ. Ер нь гэрлэх үйл явц тухайн үндэстний уламжлалтай холбоотой байдаг бөгөөд түүнд түүхийн богино хугацаанд эрс өөрчлөлт ордоггүй, харин улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн үеийн онцлогтой холбоотойгоор зарим нэгэн онцлог өөрчлөлтүүд гардаг болох нь онолын хувьд нэгэнт батлагдсан асуудал билээ. Манай орны хувьд ч энэ онолоос гажсангүй, тооллого хоорондын жилүүдэд гэрлэх үйл явцын үндсэн төрх хэвээр хадгалагдаж, харин нарийвчлан шинжлэхэд зарим нэг сонирхолтой өөрчлөлтүүд гарсан нь ажиглагдлаа. Хамгийн мэдэгдэхүйц өөрчлөлт бол арван тав, түүнээс дээш насны огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 2000 оны тооллогоор 1979 оны эрэгтэйчүүдээс 8.9, эмэгтэйчүүдээс 11.2 пунктээр харин 1989 оны эрэгтэйчүүдээс 7.4, эмэгтэйчүүдээс 8.3 пунктээр өндөр байгаа явдал юм. Энэ нь залуучуудын, тэр дундаа эрэгтэйчүүдийн гэрлэх нас хойшилж, хожуу гэрлэдэг болсоныг харуулж байна. Гэрлэлтийн байдал нь амьдралын хугацаа, насжилтын үйл явцтай нягт холбоотой байдаг тул нас, хүйсийн ялгавартай байдлаар судлах шаардлага гарч ирдэг. Хүснэгт 2-т арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг тухайн насны бүлэгт эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр нь авч үзэхэд огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь эхний хоёр насны бүлэгт, ялангуяа 15-19 насны бүлэгт хамгийн өндөр байна. Тэр тусмаа эрэгтэйчүүдийн дийлэнхи нь гэрлээгүй байна. Энэ нь Монгол Улсын гэр бүлийн тухай хуулинд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй гэрлэх насыг 18 насаар заасан учраас тухайн насны бүлгийн нэлээд хэсэг нь 18 хүртэлх насанд багтаж байгаатай холбоотой. Цаашилбал 20-24, 25-29 насны бүлгүүдэд дээрх ялгаатай байдал нь их болсон байна.

Хүснэгт 2. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэрлэлтийн байдал, хувиар, насны бүлэг, хүйсээр, 1979, 1989, 2000 оны тооллогоор

Насны бүлэг	Гэрлэлтийн байдал				Бүгд	
	Огт гэрлээгүй	Батлуулсан / батлуулаагүй гэр бүлтэй	Цуцалсан / Тусгаарласан	Бэлбэсэн	Хувь	Тоо
1979						
Эрэгтэй						
Бүгд 15+	27.7	66.2	1.6	4.5	100.0	385507
15-19	98.2	1.8	0.0	0.0	100.0	37832
20-24	73.1	26.4	0.4	0.1	100.0	64083
25-29	23.2	75.0	1.5	0.3	100.0	45432
30-34	9.0	88.3	2.0	0.7	100.0	39006
35-39	5.7	91.0	2.2	1.1	100.0	39743
40-44	4.3	91.2	2.2	2.3	100.0	33569
45-49	4.0	90.0	2.3	3.7	100.0	30124
50-54	3.4	88.2	2.4	6.0	100.0	23511
55-59	3.2	85.6	2.4	8.8	100.0	21247
60+	4.9	71.2	1.9	22.0	100.0	50960
Эмэгтэй						
Бүгд 15+	18.5	64.6	2.1	14.7	100.0	393225
15-19	84.6	15.0	0.3	0.1	100.0	36512
20-24	39.9	58.0	1.8	0.3	100.0	65533
25-29	10.5	85.6	3.1	0.8	100.0	47086
30-34	5.0	90.0	3.2	1.7	100.0	37951
35-39	4.6	88.4	3.2	3.8	100.0	36833
40-44	4.0	86.1	2.9	7.0	100.0	31330
45-49	3.8	82.0	2.4	11.8	100.0	28588
50-54	3.4	74.1	2.2	20.3	100.0	22167
55-59	3.9	64.4	1.9	29.8	100.0	22121
60+	5.0	34.2	1.2	59.6	100.0	65104

Огноо 2-дээгийн гэрлэлтийн байдал

Насны бүлэг	Гэрлэлтийн байдал				Бүгд	
	Огт гэрлээгүй	Батлуулсан / батлуулаагүй гэр бүлтэй	Цуцалсан / Тусгаарласан	Бэлбэсэн	Хувь	Тоо
1989						
Эрэгтэй						
Бүгд 15+	29.2	66.3	1.2	3.3	100.0	519877
15-19	98.4	1.6	0.0	0.0	100.0	43838
20-24	75.1	24.6	0.2	0.1	100.0	97505
25-29	24.0	74.6	1.2	0.2	100.0	88747
30-34	8.5	89.4	1.7	0.4	100.0	67249
35-39	4.8	92.6	1.8	0.8	100.0	46614
40-44	3.6	93.2	1.8	1.4	100.0	35764
45-49	3.7	91.6	2.0	2.7	100.0	35413
50-54	3.5	89.3	1.8	5.4	100.0	28157
55-59	3.4	86.2	1.9	8.5	100.0	24569
60+	3.7	73.3	1.3	21.7	100.0	52021
Эмэгтэй						
Бүгд 15+	21.4	65.4	2.0	11.2	100.0	532075
15-19	91.0	8.7	0.2	0.1	100.0	41421
20-24	47.8	50.8	1.1	0.3	100.0	98547
25-29	15.1	81.3	2.8	0.8	100.0	90796
30-34	7.6	87.1	3.6	1.7	100.0	68035
35-39	4.9	88.4	3.4	3.3	100.0	46001
40-44	4.0	86.4	3.0	6.6	100.0	34626
45-49	4.1	81.4	2.6	11.9	100.0	32883
50-54	4.0	75.4	2.0	18.6	100.0	27273
55-59	3.3	67.0	1.1	28.6	100.0	25651
60+	4.5	39.2	0.6	55.7	100.0	66842
2000						
Эрэгтэй						
Бүгд 15+	36.6	58.5	2.1	2.8	100.0	749890
15-19	98.7	1.3	0.0	0.0	100.0	133327
20-24	70.7	28.8	0.5	0.0	100.0	118023
25-29	31.2	66.7	1.9	0.2	100.0	107962
30-34	13.5	82.6	3.4	0.5	100.0	92473
35-39	7.3	87.8	4.0	0.9	100.0	84846
40-44	4.1	90.3	3.9	1.7	100.0	62619
45-49	3.4	90.0	3.6	3.0	100.0	40562
50-54	2.8	89.2	3.0	5.0	100.0	27707
55-59	3.0	85.4	2.6	9.0	100.0	27379
60+	2.8	70.8	2.0	24.4	100.0	54992
Эмэгтэй						
Бүгд 15+	29.7	57.1	3.3	9.9	100.0	774482
15-19	94.4	5.5	0.1	0.0	100.0	130031
20-24	51.7	46.8	1.3	0.2	100.0	117728
25-29	20.9	74.7	3.5	0.9	100.0	108690
30-34	10.0	81.8	6.0	2.2	100.0	95399
35-39	6.6	82.9	6.5	4.0	100.0	87760
40-44	4.9	81.3	6.3	7.5	100.0	64601
45-49	4.0	77.6	5.1	13.3	100.0	42326
50-54	3.3	71.7	3.7	21.3	100.0	30128
55-59	3.5	62.0	2.6	31.9	100.0	28516
60+	3.2	33.1	1.0	62.7	100.0	69303

Гэрлэсэн болон хамт амьдардаг, 20-24 насны залуучуудын тухайн насныханд эзлэх хувийг хүйсээр авч үзэхэд 1979 онд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 31.6, 1989 онд 26.2, 2000 онд 18.0 пунктээр тус тус өндөр байснаа 25-29 буюу түүнээс дээших насны бүлгүүдэд хүйсийн ялгаатай байдал багасаж байгаа нь ажиглагдаж байна. Үүнийг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуу насандаа гэрлэдэгтэй холбон тайлбарлаж болох юм.

15-19 насны огт гэрлээгүй хүн амыг хүйсээр авч үзэхэд, бусад насны бүлгүүдээс харьцангуй бага зөрөөтэй, тухайлбал 1979 онд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 13.6, 1989 онд 7.4, 2000 онд 4.3 пунктээр (тооллогын он хойшлох тутам багассан байна) их байна. Харин энэ зөрүү 20-24, 25-29 насны бүлэгт улам нэмэгдэж байна. Сүүлийн 3 тооллогын дүнгээс харахад анхаарал татаж буй нэг үзүүлэлт бол гэр бүлээ цуцалсан, тусгаарласан хүмүүсийн эзлэх хувь өсч, бэлбэсэн хүн амын тоо буурч байгаа явдал юм. Гэр бүлээ цуцалсан, тусгаарласан арван тав, түүнээс дээш насны хүн ам 2000 оны тооллогоор 1979 оны эрэгтэйчүүдээс 0.5, эмэгтэйчүүдээс 1.2, 1989 оны эрэгтэйчүүдээс 0.9, эмэгтэйчүүдээс 1.3 пунктээр тус тус өссөн байна. Харин хүйсийн ялгаатай байдлаар харахад аль ч тооллогоор эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаагаас, гэр бүлээ цуцалсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол дахин гэрлэх магадлал өндөр байдагтай гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Жар, түүнээс дээш насны бүлэгт бэлбэсэн хүмүүсийн эзлэх хувь, ялангуяа эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна. Тухайлбал, бэлбэсэн эмэгтэйчүүдийн хувь 1979 онд эрэгтэйчүүдээс 37.6, 1989 онд 34.0, 2000 онд 38.3 пунктээр тус тус илүү байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү урт насалдагтай холбоотой юм.

Анхны гэрлэлтийн дундаж нас (АГДН) түүний ялгавартай байдал

Гэрлэлтийн судалгааны үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь анхны гэрлэлтийн дундаж нас бөгөөд энэ үзүүлэлтийг тодорхойлсноор тухайн улсын хүн амын гэрлэлтийн ерөнхий төлөв байдлыг дүгнэх боломжтой юм. Үүнээс гадна, хүүхэд төрүүлэх эмэгтэйчүүд болон тэдний анхны гэрлэлтийн насыг судлах шаардлага гардаг. Гэрлэх нас нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг ба энэ нь тухайн хүний физиологийн хүчин зүйлүүдээс гадна улс орны уламжлал, ёс заншил, хүн амын боловсролын түвшин, түүнийг эзэмших хугацаа, бие даан амьдрах боломж, нөхцөл, мэдлэг, мэргэжил, эдийн засгийн хөгжил, хүйсийн харьцаа гэх мэт хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлүүдээс хамаардаг.

Улсын хэмжээнд 1979, 1989, 2000 оны тооллогоор эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн насны ялгаа ойролцоогоор хоёр насны зөрүүтэй, өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2 жилийн өмнө гэрлэж байна. Энэ зөрүү 1979, 1989 оны тооллогын хооронд 1 жил хагас, харин 1989, 2000 оны тооллогын хооронд 2 жил хагас болон өсчээ.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын байдлаар улсын дунджаар эмэгтэйчүүд 23.7 насандаа, эрэгтэйчүүд 25.7 насандаа анх гэр бүл болж байна.

Энэ байдлаас дүгнэхэд, сүүлийн жилүүдэд эрэгтэйчүүд орой гэрлэж байгаа нь нэг талаас зах зээлийн өнөөгийн нөхцөлд гэр бүл болох бэлтгэл, эдийн засгийн боломжоо хангах, сурч боловсрох зэрэг олон шалтгаанаас хамаарч байж болох ба нөгөө талаас залуучуудын үүрэг хариуцлага, ухамсар, амьдрах ухаанд өөрчлөлт гарсантай ч холбоотой байж болох талтай.

Хотын эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд нь хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг бодвол ойролцоогоор 1 насаар орой гэрлэж байна. Энэ үзүүлэлтийг аймаг, нийслэл, тооллого явагдсан он тус бүрээр авч үзэхэд (Хүснэгт 3), 1979 оны тооллогоор Архангай, Баян-өлгий, Дорнод, Өвөрхангай,

Увс, Ховд, Орхон аймгийн эрэгтэйчүүдийн АГДН улсын дунджаас бага, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өмнөговь аймгуудынх их, бусад аймгууд ойролцоо түвшинд байсан бол эмэгтэйчүүдийн хувьд Дундговь, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотын эмэгтэйчүүд улсын түвшинтэй ойролцоо Баян-Өлгий, Говь-Алтай аймгийн эмэгтэйчүүдийнх их, бусад аймгийн эмэгтэйчүүдийнх улсын түвшнээс доогуур байна. Харин 1979-өөс 1989 оны тооллогын хооронд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гэрлэлтийн нас 1 жил хагасаар хойшилсон ба аймгуудын хувьд улсын дүнгийн энэ чиг хандлагаас бага, 0.3 жилээр орой гэрлэх болсон байна.

2000 оны тооллогоор Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын эрэгтэйчүүдийн АГДН улсын дундаж түвшинээс их, Завхан, Сэлэнгэ, Төв аймгууд ойролцоо бусад аймгуудынх бага байгаа бол Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийнх их, Дорнод, Орхон аймаг ойролцоо, бусад аймгуудийнх доогуур түвшинд байна.

Хүснэгт 3. Анхны гэрлэлтийн дундаж нас аймаг, нийслэл, хүйс, хот, хөдөөгөөр, 1979, 1989, 2000 оны

Аймаг, нийслэл	1979					
	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	21.9	19.6	22.1	19.5	21.6	18.3
Архангай	21.4	18.2	22.0	17.6	20.3	17.6
Баян-Өлгий	20.7	20.2	20.4	17.7	20.8	17.7
Баянхонгор	22.0	18.5	22.5	18.3	21.8	19.0
Булган	21.7	18.3	21.7	18.8	21.7	18.1
Говь-Алтай	22.5	19.9	23.0	20.1	22.4	22.9
Дорноговь	21.9	18.2	21.3	17.9	22.9	18.9
Дорнод	21.4	18.8	21.9	19.2	20.8	18.2
Дундговь	22.5	19.4	22.8	19.2	22.5	19.5
Завхан	22.3	18.6	22.3	19.7	22.2	18.0
Өвөрхангай	21.3	18.0	21.6	18.8	21.3	17.7
Өмнөговь	22.9	18.4	22.9	17.7	22.9	19.1
Сүхбаатар	21.7	18.4	21.6	18.1	21.8	18.6
Сэлэнгэ	21.9	18.2	21.9	18.0	21.8	18.4
Төв	21.6	18.1	21.3	18.2	21.8	18.1
Увс	20.9	17.9	21.5	18.5	20.6	17.6
Ховд	21.3	18.8	21.4	18.3	21.3	19.2
Хөвсгөл	21.7	18.2	22.4	18.4	21.3	18.1
Хэнтий	21.9	18.8	21.7	18.7	22.1	18.8
Дархан-Уул*	21.8	19.4	21.8	19.4	-	-
Улаанбаатар	21.8	19.3	21.8	19.3	-	-
Орхон*	20.3	17.7	20.3	17.7	-	-
Говьсүмбэр**	-	-	-	-	-	-
	1989					
Бүгд	23.3	21.1	22.0	20.3	21.7	19.0
Архангай	21.7	20.0	22.1	20.4	19.5	19.1
Баян-Өлгий	20.6	18.8	20.4	18.6	20.7	18.9
Баянхонгор	21.8	19.0	22.1	20.0	21.8	18.8
Булган	21.8	19.3	22.2	20.1	21.6	19.0
Говь-Алтай	22.6	19.6	22.6	20.7	23.3	19.2
Дорноговь	21.9	18.8	21.7	19.1	22.3	18.4
Дорнод	21.4	19.5	21.4	19.9	21.5	19.0
Дундговь	21.5	18.9	21.0	19.2	21.8	18.9
Завхан	22.1	19.6	22.1	20.3	22.0	19.3
Өвөрхангай	22.0	19.1	22.0	19.1	22.0	19.2
Өмнөговь	21.7	19.1	21.4	18.0	22.0	20.0
Сүхбаатар	21.6	19.0	21.7	19.3	21.7	19.0
Сэлэнгэ	21.8	19.3	21.5	19.3	22.0	19.3
Төв	21.5	18.9	21.2	19.2	21.5	18.5
Увс	21.5	19.0	21.6	19.3	21.5	18.9
Ховд	21.4	19.4	21.3	20.2	21.4	19.0
Хөвсгөл	22.0	19.1	22.1	19.7	21.9	18.9
Хэнтий	21.2	18.6	21.1	18.5	21.3	18.8
Дархан-Уул*	21.6	20.2	21.6	20.2	-	-
Улаанбаатар	21.8	20.2	21.8	20.2	-	-
Орхон*	21.1	19.4	21.1	19.4	-	-
Говьсүмбэр**	-	-	-	-	-	-
	2000					
Бүгд	25.7	23.7	26.1	24.6	25.2	22.3
Архангай	24.8	22.5	25.8	24.6	24.6	22.0
Баян-Өлгий	24.2	22.8	24.6	23.3	24.0	22.5
Баянхонгор	25.1	22.5	26.3	24.7	24.8	21.7
Булган	25.3	22.4	26.4	23.8	25.0	21.9
Говь-Алтай	26.1	22.9	26.5	24.4	25.9	22.2
Дорноговь	25.2	22.1	24.9	22.6	25.4	21.7
Дорнод	26.0	23.8	26.2	24.4	25.7	23.1
Дундговь	25.2	22.1	25.7	23.4	25.1	21.7
Завхан	25.6	23.0	26.3	24.9	25.4	22.3
Өвөрхангай	25.2	22.9	26.1	24.4	25.0	22.6
Өмнөговь	25.0	21.1	25.3	22.6	24.8	20.2
Сүхбаатар	26.3	23.0	27.0	23.8	26.0	22.7
Сэлэнгэ	25.7	23.0	25.5	23.1	25.9	22.9
Төв	25.6	22.7	25.5	23.7	25.7	22.5
Увс	25.1	22.5	26.0	23.7	24.8	22.1
Ховд	25.4	23.2	25.9	24.7	25.2	22.6
Хөвсгөл	26.1	22.7	26.6	24.4	25.4	22.0
Хэнтий	25.0	22.4	25.1	23.0	24.9	22.1
Дархан-Уул	25.8	24.2	25.8	24.4	25.8	23.3
Улаанбаатар	26.3	25.1	26.3	25.1	-	-
Орхон	25.3	23.7	25.3	23.7	25.7	23.8
Говьсүмбэр	25.4	23.3	25.2	23.2	25.6	23.5

* Дархан-Уул, Орхон аймаг нь хотын ангилалд ордог байсан учир хөдөөд АГДН тооцох боломжгүй.

** Дорноговь аймгаас Говьсүмбэр аймаг нь тусгаарлаагүй байсан учир АГДН тооцох боломжгүй.

тооллогоор

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор монголын иргэдийг 30 гаруй гол ястан үндэстнээр ангилан гаргасан. Нийт хүн амын дийлэнхи буюу 81.5 хувийг халх ястан, 4.3 хувийг казах үндэстэн, үлдсэнийг бусад ястан үндэстэн тухайлбал, дөрвөд, баяд, буриад, дарьганга, захчин, урианхай зэрэг эзэлж байна.

Хүснэгт 4-т нийт хүн амд ихэнх хувийг эзэлж буй халх, казах, мөн багагүй хувийг эзэлж байгаа, тооцох боломжтой тоон мэдээлэлтэй ястан болон гадаадын харъяат хүн амын АГДН-тыг үзүүлэв.

Хүснэгт 4. Анхны гэрлэлтийн дундаж нас яс үндэс, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 оны

Яс үндэс	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	25.7	23.7	26.1	24.6	25.2	22.3
Халх	25.7	23.6	26.0	24.5	25.2	22.1
Казах	24.3	23.0	25.0	23.8	23.9	22.6
Дөрвөд	25.8	23.9	26.4	24.9	25.2	22.6
Буриад	26.3	24.6	26.7	25.7	25.7	23.2
Баяд	25.6	24.0	26.3	25.4	24.8	22.5
Дарьганга	26.3	24.0	26.9	25.2	25.7	22.9
Урианхай	26.5	24.4	27.2	25.3	26.1	23.7
Захчин	25.7	23.5	26.6	25.9	25.1	21.7
Дархад	26.5	22.8	27.6	25.0	26.0	22.0
Торгууд	26.6	24.7	26.6	25.8	26.5	23.6
Өөлд	26.1	25.0	26.3	26.2	25.9	23.5
Хотгон	24.5	22.3	25.8	24.0	23.8	21.4
Мянгад	26.3	25.3	26.8	25.8	25.7	25.0
Хотгойд	25.4	22.7	26.9	26.0	24.8	21.6
Гадаадын харъяат	26.8	25.8	26.9	25.8	26.3	23.2

тооллогоор

Ерөнхийдөө ихэнх ястан, үндэстний эрэгтэйчүүд дунджаар 24-27 насандаа, эмэгтэйчүүд 21-26 насандаа гэрлэж 1-2 насны зөрүүтэй байна. Халх ястаны хувьд анхны гэрлэлтийн дундаж нас хүйс болон байршлаар улсынхтай адил, харин гадаадын харъяат болон монголын харъяат бусад ястан үндэстнээс торгуудууд хамгийн орой, казахууд хамгийн эрт гэрлэдэг байна. Байршлын хувьд хотынхон хөдөөнийхнөөс арай хожуу гэрлэдэг ажээ.

Монгол улсын Үндсэн Хуульд, хүнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, хүйс, яс үндсээр ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасан байдаг. Тиймээс ч өнөөдөр манай улс бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшингээр дэлхийн хөгжилтэй орнуудын түвшинд ойртон очоод байна. 1989 онд боловсролгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү байсан бол 1989-2000 оны хооронд буурч, 2000 он гэхэд бараг ижил түвшинд хүрчээ. Ялангуяа эмэгтэйчүүдийн дунд бага боловсролтой хүмүүсийн эзлэх хувь нэлээд өссөн байна. 2000 оны тооллогоор боловсролын түвшинг хүйсийн ялгаатай байдлаар авч үзэхэд бага, дунд, техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс ялимгүй илүү, харин боловсролын өндөр түвшинд, тухайлбал тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, дээд боловсролын түвшинд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс харьцангуй давамгайлж байна.

Гэрлэлтийн дундаж насны төлөвийг боловсролтой нь уялдуулж үзвэл өнгөрсөн 10 жилийн хугацаанд хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин болон боловсролын түвшин дээшилснээр гэрлэх нас оройтож, 1989-2000 оны тооллогын хооронд АГДН 2.4-2.6 жилээр нэмэгдэж, эрэгтэйчүүдийн хувьд 25.7, эмэгтэйчүүдийн хувьд 23.7 болжээ. Энэ нь залуучууд ялангуяа охид, бүсгүйчүүд

сурч боловсрохдоо илүү анхаардаг болсонтой холбоотой. Түүнчлэн 1990-2000 оны хооронд гэрлэлтийн ерөнхий коэффициент (ГЕК) 16.9-9.0 болж 47 хувиар буурсан нь хүн амын анхны гэрлэлтийн дундаж нас хойшлоход нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй байна (Хүснэгт5).

Хүснэгт 5. Анхны гэрлэлтийн дундаж нас боловсрол, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 оны тооллогоор

Боловсролын түвшин	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	25.7	23.7	26.1	24.6	25.2	22.3
Бичиг үсэг мэддэггүй	30.2	31.2	31.4	33.1	29.9	30.4
Бага боловсрол эзэмшээгүй						
бичиг үсэг мэддэг	27.1	27.0	28.2	28.8	26.7	26.4
Бага	26.0	24.5	28.0	26.5	25.5	23.9
Бүрэн бус дунд	25.6	23.0	26.3	23.9	25.0	22.2
Бүрэн дунд, техник	25.7	24.0	25.9	24.6	25.1	22.4
Дипломын дээд	25.3	24.9	24.5	24.5	24.4	22.8
Дээд	25.1	25.2	25.1	25.4	25.0	24.0

Энд анхаарал татаж буй нэг үзүүлэлт бол боловсролгүй буюу бага боловсролтой хүн ам багаас дээш боловсролтой хүн амыг бодвол орой гэрлэж байгаа явдал юм. Ялангуяа хотод бага боловсролтой эрэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж нас дээд боловсролтой эрэгтэйчүүдийг бодвол бага байна. Магадгүй үүнийг эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдсэн, мөн дээд боловсролтой эмэгтэйчүүд өөрийн ижил боловсролтой эрэгтэйчүүдтэй гэрлэх сонирхолтой байдагтай холбон тайлбарлаж болох юм. Гэвч энэ асуудалд тодорхой хариулт өгөхийн тулд цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай болно.

Боловсролгүй хүн амаас бичиг үсэг мэддэггүй эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн АГДН хот, хөдөөд аль алинд нь 1-2 жилийн зөрөөтэй байхад бичиг үсэг мэддэг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд мөн хот, хөдөөд дөнгөж 0.1-0.6 жилийн зөрүүтэй байна.

Харин багаас дээш боловсролтой хүн амын хувьд хүйс хоорондын зөрүүтэй байдал нь боловсролын түвшин дээшлэх тутам багасаж байгаа бол харин хот, хөдөөгийн хувьд хотоосоо хөдөөд илүү зөрүү ажиглагдаж байна. Үүнийг манай улсын эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр байдаг учраас гэрлэлтээ эрэгтэйчүүдтэй бараг ижил хугацаагаар хойшлуулдаг болжээ гэж хэлж болохоор байна.

Монгол Улсын арван тав, түүнээс дээш насны хүн амын 60 гаруй хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчинд багтаж байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо хэдийгээр өндөр байгаа ч гэсэн эрэгтэйчүүдийнхээс доогуур байна. Дээрх ялгааг байршлаар авч үзвэл хот, хөдөөгийн аль алинд нь эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа ба ялангуяа энэ зөрүү хөдөөд хотоос өндөр байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Анхны гэрлэлтийн дундаж насыг эдийн засгийн идэвхийн байдлаар тооцож үзэхэд ажил эрхэлдэг эрэгтэйчүүд 25, эмэгтэйчүүд 23 насандаа гэрлэдэг бол харин ажилгүй эрэгтэйчүүд (26), эмэгтэйчүүд (24) 1 насаар хойно гэрлэдэг нь эрэгтэйчүүд амьжиргааны орлоготой болсныхоо дараа гэр бүл болдогтой холбоотой гэж үзэх хэрэгтэй.

Эдийн засгийн идэвхгүй хүн амын хувьд хамгийн орой гэрлэж байгаа нь өвчтэй, тахир дутуугийн группт байдаг эрэгтэйчүүд (31 настайдаа), эмэгтэйчүүд (30 настайдаа) байгаа ба тэдний гэрлэх нас улсын дундажтай харьцуулахад ойролцоогоор бараг 5 жилээр орой байна. Харин сургуульд сурдаг эрэгтэйчүүд 28, эмэгтэйчүүд 27 насандаа гэрлэдэг ажээ (Хүснэгт6).

Хүснэгт 6. Анхны гэрлэлтийн дундаж нас эдийн засгийн идэвхийн байдал, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 оны тооллогоор

Эдийн засгийн идэвхи	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Ажиллах хүч	25.3	23.1	25.6	24.4	25.0	21.7
Ажил эрхэлдэг	25.1	22.8	25.2	24.5	24.9	21.5
Ажилгүйчүүд	26.2	23.9	26.3	24.0	25.9	23.7
Эдийн засгийн идэвхигүй	27.2	24.5	27.2	24.7	26.9	23.7
Тохирох ажил олдохгүй байгаа	26.2	24.3	26.3	24.5	25.8	23.5
Сургуульд сурдаг	27.5	26.5	28.7	27.3	_*	_*
Өвчтэй, тахир дутуугийн группт	30.6	29.5	30.0	28.8	31.6	30.6
Гэрийн ажилтай	25.6	20.3	25.5	19.9	25.8	20.6

* Бага тоотой учраас АГДН тооцох боломжгүй.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам нийтдээ 580.3 мянга байгаагаас 171.0 мянга нь сургуульд сурдаг гэж хариулсны 84.1 хувь нь хотод сурдаг учраас хөдөөд тооцох боломжгүй байв. Өвчтэй, тахир дутуугийн группт байдаг хүмүүс буюу сургуульд сурдаг хүмүүсийн АГДН-ны хүйсийн зөрүү 1 жил байхад тохирох ажил олдохгүй байгаа гэж хариулагсдын насны зөрүү 2 жил байна (эрэгтэйчүүд 26, эмэгтэйчүүд 24). Жич: эдгээр хүмүүсийг "итгэл алдарсан ажилчид" гэж нэрлэдэг бөгөөд тэд хэрэв ажил олдрвол ажиллах хүчинд багтах боломжтой.

Эдийн засгийн идэвхгүй хүн амаас гэрийн ажилтай эрэгтэйчүүд 25 насандаа, эмэгтэйчүүд 20 насандаа гэрлэдэг ба өөрөөр хэлбэл анхны гэрлэлтийн насны ялгаа 5 жилийн зөрүүтэй байна. Үүнийг эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн үүрэг, уламжлалт ёс заншилтай холбоотойгоор, харин эрэгтэйчүүдийн хувьд орлоготой холбоотойгоор тайлбарлаж болно.

Судалгааны энэ хэсэгт АГДН-ыг ажил мэргэжлийн ялгаатай байдал, болон өнөөгийн мөрдөж буй ажил мэргэжлийн ангиллын дагуу тооцож гаргав (Хүснэгт7). Манай оронд хэдийгээр эмэгтэйчүүд боловсролын түвшингийн хувьд давамгайлж байгаа хэдий ч удирдах албан тушаалтан буюу менежер нарын дөнгөж 30 хувийг эзэлж байгаа бөгөөд харин мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудын дийлэнхи нь эмэгтэйчүүд байна. Хөдөө аж ахуйн ажилчин буюу машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч гэсэн мэргэжлээр эрэгтэйчүүд давамгайлж байна.

Хүснэгт 7. Анхны гэрлэлтийн дундаж нас ажил мэргэжил, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 оны тооллоогоор

Ажил мэргэжил	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	25.1	22.8	25.2	24.5	24.9	21.5
Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалын ажилтан, менежер	23.3	24.1	23.4	24.4	23.2	22.4
Мэргэжилтэн	24.7	24.4	24.8	24.9	24.0	22.4
Инженер техникийн ажилтан	24.5	24.0	24.5	24.5	24.5	22.1
Туслах ажилтан /Клерк/	24.1	23.9	24.4	24.4	23.2	21.1
Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч	24.5	23.7	24.6	24.0	24.0	22.4
Хөдөө аж ахуй ба загасны аж ахуйн мэргэшсэн ажилчин	25.1	21.6	26.6	23.1	25.0	21.4
Үйлдвэрийн ба худалдааны ажилчин	25.2	24.9	25.3	25.1	24.6	22.9
Машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагч	24.4	24.4	24.5	24.4	24.2	24.3
Энгийн ажил мэргэжил	25.2	23.8	25.3	24.1	24.5	22.5

Хүснэгт 7-оос харахад ихэнх ажил мэргэжлийнхний анхны гэрлэлтийн дундаж нас эрэгтэйчүүдийн хувьд хот хөдөөд ялгаагүй 25 байхад эмэгтэйчүүдийн хувьд арай өөр хотод 24, хөдөөд 22 насандаа гэрлэж байна.

Мэргэжлээр нь авч үзвэл хөдөө аж ахуй ба загасны аж ахуйд ажилладаг эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ 4 насаар орой гэрлэдэг нь бусад ажил мэргэжлийнхнээс хүйсийн хувьд хамгийн их зөрүүтэй байна. Энэ нь нийт ажиллагсдын 46 хувь, харин хөдөөд ажиллагсадын 80 хувь нь хөдөө аж ахуйд ажил эрхэлдэг, тэдгээрийн дийлэнх нь эрэгтэйчүүд байдагтай холбоотой.

Бусад мэргэжлийнхний анхны гэрлэлтийн дундаж нас бараг ялгаагүй, эрэгтэйчүүд дунджаар 23-25 насандаа, эмэгтэйчүүд 21-24 насандаа ихэвчлэн гэрлэдэг байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор ажил эрхэлж байгаа хүн амын бараг тал хувь нь хөдөө аж ахуй (47.2 хувь), уул уурхайн (2.4 хувь) салбарт ажиллаж байгаагаас гадна ажил эрхэлж байгаа хүн амын 40 орчим хувийг багтаадаг үйлчилгээний салбарууд хоёрдугаарт орж байна (Хүснэгт8). Хөдөө аж ахуй, уул уурхайн тэргүүлэх салбарынхны анхны гэрлэлтийн дундаж нас дээр дурьдсанчлан хөдөө аж ахуйн ажил эрхэлдэг хүн амтай ижил байна.

Хүснэгт 8. Анхны гэрлэлтийн дундаж нас эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйс, хот, хөдөөгөөр, 2000 оны тооллогоор

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Бүгд		Хот		Хөдөө	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	25.1	22.8	25.2	24.5	24.9	21.5
Хөдөө аж ахуй, загас, ан агнуур, ойн аж ахуй, уул уурхай, олборлох үйлдвэр	25.1	21.6	25.8	23.0	25.0	21.5
Боловсруулах үйлдвэр	25.6	25.2	25.7	25.3	25.3	23.4
Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	24.7	22.4	24.8	22.5	24.1	22.2
Барилга	25.6	24.0	25.7	24.0	24.9	24.0
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	24.2	23.6	24.2	23.7	24.3	22.8
Зочид буудал, зоогийн газар	25.8	24.9	26.0	25.0	24.4	24.0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	24.2	23.7	24.3	23.8	23.7	22.9
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	25.1	24.2	25.2	24.3	23.7	23.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа	25.2	23.4	25.3	24.5	25.0	20.0
Боловсролын салбарын үйл ажиллагаа	24.4	24.1	24.6	24.6	23.9	22.7
Эрүүл мэнд, нийгмийн халамж	24.3	24.1	24.9	24.6	23.4	22.3
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	25.3	24.6	25.4	24.8	24.5	22.0

Анхны гэрлэлтийн дундаж насыг хүйсийн ялгаатай байдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд эрэгтэйчүүд хот, хөдөө ялгаагүй 25 насандаа гэрлэдэг бол эмэгтэйчүүд арай ялгаатай хотын эмэгтэйчүүд 24, хөдөөгийн эмэгтэйчүүд 22 насандаа гэрлэдэг байна. Харин зөрүүний хувьд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд хот, хөдөөд аль алинд нь ойролцоогоор 1 насны зөрүүтэй байна. Харин хөдөө аж ахуйн салбарын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гэрлэлтийн нас 4 насны зөрүүтэй байгаа нь мөн л нийт ажиллагсдын 47.0 хувь нь хөдөө аж ахуй, загас ан агнуур, ойн аж ахуй, уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт ажил эрхэлдэг, тэдгээрийн дийлэнх эрэгтэйчүүд байдагтай холбоотой юм.

Харин боловсрол, эрүүл мэнд болон зочид буудал, зоогийн газар, санхүүгийн үйл ажиллагаа зэрэг салбарт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс харьцангуй олон ажиллаж байгаа бөгөөд тэнд ажиллаж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн анхны гэрлэлтийн дундаж насыг бараг ялгаагүй ижил байна. Бусад салбарынхны хувьд ч анхны гэрлэлтийн дундаж нас бараг ялгаагүй эрэгтэйчүүд дунджаар 23-25 насандаа, эмэгтэйчүүд 21-24 насандаа ихэвчлэн гэрлэдэг байна.

Ерөнхий дүгнэлт

Гэрлэлтийн байдал нь хүн ам зүйн нэг гол үзүүлэлт төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад чухал ач холбогдолтой байдаг учир манай улсын удаа дараагийн хүн амын тооллогуудад бүрэн хэмжээгээрээ тусгагдаж, тус улсын хүн амын гэрлэлтийн байдлын өөрчлөлтийг харуулж байсан юм.

Арван тав, түүнээс дээш насны огт гэрлээгүй хүмүүсийн эзлэх хувь 2000 оны тооллогоор 1979 оны эрэгтэйчүүдээс 8.9, эмэгтэйчүүдээс 11.2 пунктээр, харин 1989 оны эрэгтэйчүүдээс 7.4, эмэгтэйчүүдээс 8.3 пунктээр өссөн нь залуучууд тэр дундаа эрэгтэйчүүдийн гэрлэх нас хойшилж, хожуу гэрлэдэг болсонтой холбоотой.

Гэр бүлээ цуцалсан, тусгаарласан хүмүүсийн эзлэх хувь өсч, бэлбэсэн хүн амын эзлэх хувь буурсан байна. Энэ нь гэр бүлээ цуцалсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол дахин гэрлэх магадлал өндөр байдаг бол жар, түүнээс дээш насны бүлэгт бэлбэсэн хүмүүсийн эзлэх хувь хамгийн их хувийг эзэлж байгаа нь өндөр насны бүлгүүдэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс урт насалж байгаагаар тайлбарлагдана.

Сүүлийн жилүүдэд эрэгтэйчүүд орой гэрлэж байгаа нь нэг талаас зах зээлийн өнөөгийн нөхцөлд гэр бүл болох бэлтгэл, эдийн засгийн боломжоо хангах, сурч боловсрох зэрэг олон шалтгаанаас хамаарч байж болох ба нөгөө талаас залуучуудын үүрэг хариуцлага, ухамсар, амьдрах ухаанд өөрчлөлт гарсантай ч холбоотой байж болох юм.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин болон боловсролын түвшин дээшилснээр ялангуяа боловсролын өндөр түвшинд, тухайлбал тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, дээд боловсролын түвшинд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс давамгайлах болсоноор гэрлэх нас оройтож байна.

Анхны гэрлэлтийн дундаж насыг эдийн засгийн идэвхийн байдлаар тооцож үзэхэд ажил эрхэлдэг эрэгтэйчүүд 25, эмэгтэйчүүд 23 насандаа гэрлэдэг бол харин ажилгүй эрэгтэйчүүд (26), эмэгтэйчүүд (24) 1 насаар хойно гэрлэдэг нь эрэгтэйчүүд цалин, орлоготой ажил олсныхоо дараа гэр бүл болдогтой холбоотой болов уу.

Өвчтэй, тахир дутуугийн группт байдаг хүмүүс улсын дундажтай харьцуулахад ойролцоогоор бараг 5 жилээр орой гэрлэж байна. Энэ нь эдийн засгийн идэвхгүй хүн амын хувьд хамгийн орой гэрлэлт юм. Харин сургуульд сурдаг эрэгтэйчүүд 28, эмэгтэйчүүд 27 насандаа гэрлэж байна.

Эмэгтэйчүүд боловсролын түвшингийн хувьд давамгайлж байгаа хэдий ч удирдах албан тушаалтан буюу менежер нарын 30 хувийг эзэлдэг бөгөөд харин мэргэжилтэн, инженер техникийн ажилтануудын дийлэнхи нь эмэгтэйчүүд байна. Хөдөө аж ахуйн ажилчин буюу машин тоног төхөөрөмжийн операторч, угсрагчид эрэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Анхны гэрлэлтийн дундаж нас, хүйсийн ялгааг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд эрэгтэйчүүд хот, хөдөө ялгаагүй 25 насандаа гэрлэдэг бол эмэгтэйчүүд арай ялгаатай хотын эмэгтэйчүүд 24, хөдөөгийн эмэгтэйчүүд 22 насандаа гэрлэдэг байна.

Ерөнхийдөө ихэнх ястан, үндэстэний эрэгтэйчүүд дунджаар 24-27 насандаа, эмэгтэйчүүд 21-26 насандаа гэрлэдэг бөгөөд хоорондоо 1-2 насны зөрүүтэй байна.

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжин орсноос хойш нэг талаас нийгэм, эдийн засгийн тодорхой байдлаас шалтгаалан, нөгөө талаас хувь хүмүүс, тэр тусмаа эмэгтэйчүүдийн төрөлтөө зохицуулах хүсэл сонирхол, мэдлэг дээшилсэнтэй уялдан төрөлтийн түвшин нэлээд хэмжээгээр буурсан байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн боловсрол, ажил эрхлэлтийн түвшин нэмэгдсэн нь төрөлтийн түвшин буурах бас нэг шалтгаан нь болсон билээ. Үүнтэй уялдан анхны гэрлэлтийн нас хойшилж, гэрлэлтийн ерөнхий коэффициент буурч байгааг тооллогын дүн бэлхнээ харуулж байна.

Энд хамгийн их сэтгэл эмзэглүүлж буй асуудал бол боловсрол дахь хүйсийн тэнцвэрт харьцаа алдагдсанаас болж гэрлэлт болон гэр бүл цуцлалтанд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл өсч байна. Эдгээр байдлуудад дүгнэлт хийж цаашид авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээг зөвлөмж болгож байна. Үүнд:

- Залуу гэр бүлийг дэмжих, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх
- Боловсрол дахь хүйсийн ялгавартай байдлыг арилгах
- Гэр бүл цуцлалтын шалтгааныг нарийвчлан судлах
- Төр засгийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг (хүүхэд, эмэгтэйчүүд, ядуурал гэх мэт) нийгмийн хамгааллын зарим асуудлууд болон *гэр бүлийн* хүрээнд цогц арга хэмжээ болгон чиглүүлэх шаардлагатай байна.

Улс орны хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас хүний хүчин зүйлсийг нэн тэргүүнд эрхэмлэх явдлыг гол болгодог үзэл баримтлал дэлхий дахинд нийтлэг болсон өнөө үед хүний анхдагч орчин болох тэр л цэгээс хүний хөгжлийг хангах нөхцлийг бүрдүүлэхэд төрийн бодлогыг чиглүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ном зүй:

1. National Institute of Statistics, Ministry of Planning Phnom Penh, General population Census of Cambodia 1998: Analysis of Census Results Report 2 Nuptiality, Cambodia, 1999
2. Statistical Publishing House, 1999 Population and Housing Census, Census Monograph on Marriage, Fertility and Mortality in Vietnam: Level, trends and Differentials, Vietnam, 2001
3. Үндэсний статистикийн газар, НҮБ-ын ХАС, 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн, Улаанбаатар, Монгол Улс, 2001 оны 7-р сар
4. Үндэсний статистикийн газар, НҮБ-ын ХАС, 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Хүн амын эдийн засгийн идэвхи, Улаанбаатар, Монгол Улс, 2001 оны 12-р сар
5. Үндэсний статистикийн газар, НҮБ-ын ХАС, 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Монгол улс дахь хүйсийн ялгаатай байдал, Улаанбаатар, Монгол Улс, 2002 оны 1-р сар